

1

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД, ТЭДГЭЭРИЙГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД :ОЛОН УЛСЫН СТАНДАРТ, МАНАЙ ОРНЫ ПРАКТИК

Б.Батмөнх

Abstract

This article is written based on Assessment Study Report of ADB project RETA 6356: Improving Administrative Data Sources for the Monitoring of the Millennium Development Goal's Indicators. This article has raised issues how to identify MDGs recommended by the UN and its indicators in case of Mongolia and discrepancies of international and national targets and indicators, and advanced an offer to amend resolution of the Parliament and Law on Statistics.

НҮБ-ээс зөвлөмж болгосон Мянган Хөгжлийн Зорилтууд

НҮБ-ын шууд эвээл дор хүн төрөлхтөний өмнө тулгамдсан асуудлаар дэлхий нийтийн анхаарлыг төвлөрүүлж, зөвшилцөлд хүрч, шийдвэрлэсэн чухал асуудал бол Мянган Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхээр тохиролцсон явдал юм. 2000 оны 9 дүгээр сард болсон НҮБ-ын Мянган Чуулганд оролцсон манай Ерөнхийлөгч асан Н.Багабанди Мянган Тунхаглалыг дэмжин гарын үсэг зурснаар Монгол Улс энэхүү зорилтуудыг 2015 оныг хүртэл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн билээ. Энэхүү тунхаглалд нэгдэн орсон үр дүнд манайх шиг буурай хөгжилтэй, ядуу орны хувьд хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэх гадаад таатай орчин бүрдэж, улмаар 2000-2009 онд Монгол Улсад Мянган хөгжлийн зорилтуудын хамгийн гол зорилт болсон ядуурлыг бууруулах чиглэлээр НҮБ, түүний салбар байгууллагуудаас олон тооны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирсэн билээ. Одоо дэлхий нийтээрээ хөгжиж байгаа орнуудын хөгжлийн тулгамдсан асуудлыг Мянган хөгжлийн зорилтуудын хэрэгжилттэй шууд холбон авч үздэг болжээ. Өнөөдөр НҮБ, түүний харьяа олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны нэг гол чиглэл нь Мянган хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол Улс Мянган Тунхаглалд нэгдэн орсон улсын хувьд хүлээсэн үүргийн дагуу Мянган хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх үндэсний анхны илтгэлээ 2004 онд, 2005-2006 оны хэрэгжилтийн талаарх хоёрдахь илтгэлээ 2007 онд хэвлэн гаргасан билээ. 2005 оны 4 дүгээр сард УИХ

25 дугаар тогтоолоороо НҮБ-ээс зөвлөмж болгосон Мянганы хөгжлийн зорилтууд дээр хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх зорилтыг шинээр нэмж тусган 2015 он хүртэлх хэрэгжүүлэх Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг тодорхойлсон билээ.

НҮБ-аас 2003 оны 9 сард анх батлан гаргасан Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 8 зорилго, 18 зорилт, тэдгээрийг дүгнэх 48 үзүүлэлтэй байсан. НҮБ-аас 2008 оны 1 –р сараас эхлэн мөрдүүлэхээр зөвлөмж болгосон өөрчлөлтөөр Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 8 зорилго, 21 зорилт, тэдгээрийг 60 үзүүлэлтээр дүгнэхээр болсон.

2008 оны 1 –р сард УИХ- 13 дугаар тогтоолоороо 2005 оны 25 –р тогтоолдоо өөрчлөлт оруулан шинэчилсэн. Манай орны хувьд Мянганы Хөгжлийн Зорилтууд нь 9 зорилго, 24 зорилт, тэдгээрийг 67 үзүүлэлтээр дүгнэхээр байгаа юм.

Монгол Улсын МХЗ, түүнийг дүгнэх үзүүлэлтүүдийг НҮБ-ын МХЗ, үзүүлэлттэй зэрэгцүүлбэл:

Зорилгууд	НҮБ-ын зөвлөмж болгосон МХЗ, үзүүлэлтүүд		Монгол Улсын МХЗ, үзүүлэлтүүд	
	зорилтууд	Үзүүлэлтүүд	Зорилтууд	Үзүүлэлтүүд
Зорилго 1. Ядуурал, өлсгөлөнг бууруулах	3	9	4	10
Зорилго 2. Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших	1	3	1	3
Зорилго 3. Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	1	3	3	6
Зорилго 4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах	1	3	1	3
Зорилго 5. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах	2	6	1	2
Зорилго 6. Бэлгийн замын халд-варт өвчин, ХДХВ, ДОХ, сүрьеэ-тэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	3	10	3	7
Зорилго 7. Байгаль орчны тогт-вортой байдлыг хангах	4	10	4	10
Зорилго 8. Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх	6	16	4	14
Зорилго 9. Хүний эрхийг баталгаажуулж, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	-	-	3	12
ДҮН	21	60	24	67

НҮБ-аас зөвлөмж бологосон Мянганы Хөгжлийн Зорилтуудыг өөрийн орны өвөрмөц нөхцөлд тохируулан ялангуяа нэн тулгамдсан асуудлаар, тухайлбал, хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх чиглэлээр шинэ зорилтуудыг нэмж оруулсан нь маш зүйтэй шийдвэр байсан. Манай орон эхний

8 зорилгын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг өөрийн орны нөхцөлд хэрэгцээтэй гэсэн шинэ зорилтуудаар нэмж баяжуулсан.

Харамсалтай нь бас олон улсын түвшинд зөвшилцөж тохирсон зорилтуудыг хасаж “ монголчилсон”. Өмнөх хүснэгтээс харахад Зорилго 5 –ын хүрээнд 2 зорилт дэвшүүлснийг нь манай орон нэг болгоод НҮБ- аас дэвшүүлсэн 2015 он гэхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг нийтэд хүртээмжтэй болгоно гэсэн зорилтыг манай орны хувьд огт дүгнэхгүйгээр хассан байгаа юм. Зорилго 8 –ын хүрээнд 6 зорилт дэвшүүлсэнийг манайхан 4 болгон цөөлсөн. Үүний зэрэгцээ олон улсын түвшинд тодорхой дэвшүүлсэн зорилтыг өөрийнхөөрөө өөрчилж, өндөр зорилтыг сулруулж “ монголчилсон”. Тодорхой нэг зорилтыг дүгнэхээр олон улсын түвшинд тогтсон үзүүлэлтийг өөр үзүүлэлтээр үнэлж дүгнэхээр солисон нь олон улсын стандарт талаасаа зохисгүй өөрчлөлт болсон гэж мэргэжлийн хүний хувьд үзэж байна. Үүний улмаас манай оронд Мянганы Хөгжлийн Зорилтуудыг дүгнэхээр тогтоосон 67 үзүүлэлтийн дөнгөж 32 нь олон улсын түвшинд зөвлөмж болгосон үзүүлэлт, харин 35 үзүүлэлт нь үндэсний хэмжээнд л хэрэглэх үзүүлэлт болжээ. Тухайлбал, Мянганы Хөгжлийн Зорилтуудын хамгийн эхний зорилго доторх эхний зорилтыг олон улсын түвшинд “1990 – 2015 оны хооронд өдөрт нэг ам. доллараас доогуур орлоготой хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулна” гэж тодорхойлсон бол УИХ- ын 25 –р тотоолоор үүнийг “ Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулна” хэмээн өөрчилсөн. Энэ нь өнгөцхөн харахад зарим хүнд ялгаагүй мэт бодогдох боловч мэргэжлийн үүднээс авч үзвэл их зөрүүтэйгээр зогсохгүй, угаасаа энэхүү зорилтыг хэрэгжих үндэс муутай болгосон өөрчлөлт байв. Энэхүү зорилтуудын ядуурлыг хэмжиж шугам нь тэс өөр өөр байгаа юм. Олон улсын түвшинд өдөрт нэг ам. доллараас доогуур орлоготой гэдэг үгээр ядуурлын шугамыг тогтоосон бол манайд амьжиргааны баталгаажих (баталгаажих гэдэг үг өөрөө бас буруу, яагаад гэвэл Засгийн газар баталгаажуулж чадахгүй байгаа, өөрөөр хэлбэл индексжүүлэхгүй байгаа) түвшингээр ядуурлын шугамыг авсан. Олон улсын түвшинд тогтоосон ядуурлын шугам нь дэлхийн аль ч орны хүн амыг 2015 он хүртэл адилхан хэмжихээр тогтсон харьцангуй тогтвортой шугам юм. Гэтэл манай шугам бол хуулиараа Үндэсний Статистикийн Хорооноос жил бүр инфляцийн өөрчлөлт, хэрэглээний хувийн жингээр засварлан зарлаж байдаг огт тогтворгүй шугам билээ. Энэхүү шугамаас тооцоод байгаа учраас манай оронд ядуурал буурахгүй байх нэг гол шалтгаан болдог. Учир нь ядуурлын шугам мөнгөн дүнгээрээ жил бүр өсөөд байдаг. Хүн амын худалдан авач чадвар түүнээс хурдан нэмэгдэхгүй байгаа нөхцөлд энэхүү нэмэгдээд байгаа шугамаас доогуур амьжиргаатай хүмүүс хурдан багасдаггүй тул ядуучуудын тоо цөөрдөггүй. Ингээд бид олон улсын түвшинд тогтсон стандартаас зөрүүтэй зорилт дэвшүүлж, өөр үзүүлэлт ашигласнаас НҮБ –д өдөрт нэг ам. доллараас бага орлоготой хэдэн хүн Монгол Улсад байгаа, тэдгээр нь нийт хүн амдаа хэдэн хувь эзэлж байгааг гаргаж өгч чадахгүйд хүрсээд зогсоогүй олон улсын түвшинд Монголын ядуурлыг зэрэгцүүлэх боломжгүй болсон. Тодорхой тогтсон зорилтыг ингэж өөрчилсөн нь гаргаж чаддаг тоондоо зорилтоо тохируулсан мэт санагдсан.

Манайд ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар НҮБ-ын Мянганы Хөгжлийн Зорилтуудад дэвшүүлсэн өндөр зорилтыг сулхан болгон өөрчлөөд 4 үзүүлэлтээр тусгайлан дүгнэх байсныг зөвхөн 2 үзүүлэлтээр дүгнэхээр өөрчилсөн. Иймэрхүү зорилт, үзүүлэлтүүд манай Мянганы Хөгжлийн Зорилтууд, түүнийг дүгнэх үзүүлэлтэд цөөнгүй байна.

Нөгөө талаасаа Монгол Улс Мянганы Хөгжлийн Зорилтуудаа үндэсний үзүүлэлт, зорилтуудаараа дүгнэсэн үндэсний тайланг гаргахаар НҮБ –д зориулсан өөр тайлан давхар гаргахад хүрнэ. Учир нь дэлхий нийтээр НҮБ-ээс зөвлөмж болгосон зорилтуудын хэрэгжилтийг манай үндэсний тайлан бүрэн харуулахгүй билээ. Иймээс УИХ-ын 2008 оны 13 –р тогтоолыг нэн яаралтай өөрчлөх шаардлагатай байгаа юм.

НҮБ-ын МХЗ-ыг дүгнэхэд манай оронд гаргаж чаддаг үзүүлэлтүүд, тэдгээрийн чанар, олон улсын стандарттай нийцсэн байдал

Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлсэн бүсийн RETA 6356 төслийн хүрээнд тусгай үнэлгээ хийж үзэхэд НҮБ-аас зөвлөмж болгосон 60 үзүүлэлтийн 38 буюу 63,3 хувийг нь манай албан ёсны статистик гаргадаг. Энд 1990 оноос хойш ядаж нэг оны хувьд гаргасан үзүүлэлтийг гардаг гэж үзсэн. Эдгээр 38 үзүүлэлтийн 21 нь буюу 55,3 хувь нь манай яам, агентлагуудын захиргааны мэдээллээс гардаг. НҮБ-аас зөвлөмж болгосон 60 үзүүлэлтээс манайд гардаггүй 22 үзүүлэлтийн 8 нь манай орны хувьд хамааралгүй, харин 10 гаруй үзүүлэлтийг мэдээлэл цуглуулдаггүй, арга зүйг нь мэдэхгүй шалтгаанаар тооцож чадахгүй байгаа юм.

НҮБ-ын МХЗ-ыг дүгнэх, манайд гардаг үзүүлэлтүүдийг яам, агентлагаар харуулбал:

Яам, агентлагийн нэр	Үзүүлэлтийн тоо
Үндэсний Статистикийн Хороо	15
Эрүүл мэндийн яам	10
Сангийн яам	4
Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	3
Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар	3
Байгаль орчны яам	2
Сонгуулийн Ерөнхий Хороо	1
Дүн	38

2008 оноос НҮБ –аас МХЗ-ыг дүгнэхээр шинээр нэмсэн 10 үзүүлэлтээс манай орны хувьд дараахь 7 үзүүлэлт гарах боломжтой байна. Үүнд:

- Нэг хүн амд ногдох ДНБ –ний өсөлтийн хувь
- Нийт хүн амд ажиллагсдын эзлэх хувь
- Нийт ажиллагсдад хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллагчдын эзлэх хувь
- Өсвөр охидын төрөлтийн хувь
- Эхчүүдийн төрөхийн өмнөх хяналтанд хамрагдалтын хувь

- Гэр бүл төлөвлөлтийн хүсээгүй хэрэгцээ
- 1000 хүн ногдох гар утасны тоо

Үүнийг зориуд энд дурьдаад байгаа учир нь үндэсний 2 дахь илтгэл гаргах үед эдгээр үзүүлэлт байгаагүй, дээр нь ҮСХ –ны МХЗ-ын үзүүлэлтүүдийн санд эдгээр үзүүлэлтүүд байхгүй байгаа болно. Гэхдээ эдгээр үзүүлэлтүүдийг дээрх гардаг 38 үзүүлэлтэд оруулан тооцсон.

Гол нь манайханы гаргаж байгаа 38 үзүүлэлтийг нарийвчлан шинжилж үзэхэд дараахь 6 үзүүлэлтийн хувьд ойлголт, тодорхойлолт нь олон улсын стандартаас зөрүүтэй өөр байгаа юм. Үүнийг хүснэгтээр харуулав.

Үзүүлэлтүүд, хариуцдаг байгууллага	Ойлголтын зөрүү
1.Нэгдүгээр ангид элсэн ороод 5-р анги хүртэл суралцагсад, БСШУЯ	НҮБ-ын аргачлалаар энэ үзүүлэлтийг 1 ангид элсэн орогчдын ирээдүйд 5 –р анги хүртэл суралцах хувь байдаг бол манайд одоо 5 –р ангид орсон хүүхдээс хэд нь 1-р ангиасаа явсаныг харуулдаг.
2.15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалт, ҮСХ	НҮБ энэ үзүүлэлтийг 15-24 насны залуучуудаар тооцдог бол манайд 15 –аас дээш насныханаар тооцдог тул зэрэгцүүлэх боломжгүй зөрүүтэй.
3.Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийн тархалт, ҮСХ	НҮБ эрэгтэй, эмэгтэйчүүдээр зэрэг тооцохыг зөвлөдөг бол энэ үзүүлэлтийг манайд зөвхөн эмэгтэйчүүдээр тооцдог.
4. ХДХВ,ДОХ-ын талаар зөв ойлголттой 15-24 насны залуучуудын эзлэх хувь, ҮСХ	Энэ үзүүлэлт дээрхтэй адилхан
5.Ойт нутгийн эзлэх хувь, БОЯ	НҮБ-ын ойлголтоор бол энэ үзүүлэлтийг нийт нутаг дэвсгэрээс гол мөрөн, нуурын усны тал-байг хасаж тооцдог бол манайх нийт нутаг дэвсгэрээ бүхлээр нь авдаг.
6.Сайжруулсан ариун цэврийн хангамж ашигладаг хүн амын эзлэх хувь, ҮСХ	НҮБ-ын ойлголтоор бол ариун цэврийн байгууламж, гадаах нүхэн жорлонг хамруулдаг бол манайд арай өргөнөөр усан хангаж, хог зайлуулатыг хамруулан ойлгодог.

Мөн дээрх 38 үзүүлэлтээс 5 үзүүлэлтийн тооцох арга нь олон улсын стандарт аргачлалаас зөрүүтэй байна. Иймээс эдгээр үзүүлэлтүүдийг олон улсын түвшинд үнэндээ зэрэгцүүлэхэд учир дутагдалтай юм. Тухайлбал, интернет, гар утас хэрэглэгчид, суурин телефон утасны тоог манайд 1000 хүнд ногдохоор тооцдог бол НҮБ-ын аргачлалаар 100 хүн тутамд ногдохоор тооцдог. Мөн өсвөр охидын төрөлтийн коэффициентийг манайд 100 охидод ногдохоор тооцдог бол НҮБ-ын аргачлалаар 1000 охид тутмаар тооцдог. Иймэрхүү өчүүхэн жаахан тооцох аргачлалын ялгааг дариухан өөрчлөөд олон улсын стандарттай нийцүүлмээр байна. Тооцох аргын хувьд нэлээд зөрүү БСШУЯ-наас гаргадаг нэгдүгээр ангид элсэн ороод 5-р анги хүртэл суралцагсадын тоон дээр байгаа юм. НҮБ-ын аргачлалаар үүнийг 1-5 -р ангийн хүүхдүүдээр буюу когортын аргаар тооцдог.

Түүнчлэн дээрх 38 үзүүлэлтээс 10 үзүүлэлтийн гаргадаг хугацаа хэтэрхий хол, МХЗ-ыг дүгнэх, үндэсний илтгэлийг УИХ –ын 25 –р тогтоолын дагуу 2 жил тутам гаргах шаардлагыг хангахгүй байгаа юм. Эдгээр үзүүлэлтүүдийг ихэвчлэн 10 жил тутамд нэг удаа явагддаг хүн амын тоолоого, 3-5 жил тутамд хийгддэг түүвэр судалгаагаар цуглуулдаг тоо мэдээлээс гаргадаг тул гардаг давтамж нь урт байдаг. Ийм үзүүлэлтэд дараахь үзүүлэлтүүд ордог.

Үндэсний нийт хэрэглээнд хамгийн ядуу бүлгийн эзлэх хувь (1.3)
Нийт ажиллагсад хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон өрхийн бизнест цалин хөлсгүй ажиллагчдын эзлэх хувь (1.7)
Тав хүртэлх насны зохих жиндээ хүрээгүй хүүхдийн эзлэх хувь (1.8)
15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалт (2.3)
Өсвөр охидын төрөлтийн хувь (5.3)
Эхчүүдийн төрөхийн өмнөх хяналтанд хамрагдалтын хувь (5.5)
Гэр бүл төлөвлөлтийн хүсээгүй хэрэгцээ (5.6)
ХДХВ,ДОХ-ын талаар зөв ойлголттой 15-24 насны залуучуудын эзлэх хувь (6.3)
Ундны усны сайжруулсан эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь (7.9)
Сайжруулсан ариун цэврийн хангамж ашигладаг хүн амын эзлэх хувь (7.9)

Түүнчлэн дараахь 13 үзүүлэлтийн хувьд МХЗ-ыг дүгнэх шаадлагын түвшинд хүйс болон хот хөдөөгийн ялгаатайгаар задрахгүй байгаа юм. Эдгээр үзүүлэлтийн код нь 1.5; 1.7; 1.8; 2.1; 2.2; 4.1; 4.2; 4.3; 5.4; 5.5; 6.9; 7.8 7.9. болно. Тухайлбал, БСШУЯ –наас гаргадаг сургуульд хамрагдалтын цэвэр жин гэхэд хүйсийн ялгаатайгаар гарахгүй байгаа юм. Гэтэл МХЗ-ыг хэрэгжилтийг үнэлэхэд энэ үзүүлэлтийн хүйсийн ялгавартай байдал маш чухал байдаг.

Ер нь яам, агентлагуудын захиргааны мэдээллээс гаргадаг зарим үзүүлэлтийн үнэн зөв байдал, хамралт, чанарын хувьд ч анхаарах асуудал бий. Төрөлт,нас баралтын үзүүлэлтүүд ҮСХ, Иргэний бүртгэлийн байгууллага, ЭМЯ –ны эх үүсвэрээр өөр өөрөөр гарсаар ирсэн. ЭМЯ –ны мэдээгээр гарсан нялхсын эндэгдлэл ҮСХ-ноос явуулдаг нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаагаар гарсан үр дүнгээс дандаа бага гарсаар ирсэн. Цаашид нэг үзүүлэлтийг хэд хэдэн байгууллага давхан гаргаж байгаа нь улсын хэмжээнд мэдээллийн давхардлыг гаргуулахгүй байх талаар “Статистикийн тухай “ Монгол Улсын хуулийн 1-дугаар зүйлийн 4 –р хэсэгт заасан “ захиргааны статистикийн мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэлтэй давхардуулахгүй байх” талаар Үндэсний Статистикийн Хорооны хүлээх үүрэг хэрэгжихгүй байгаа юм. Үүнийг засаж залруулаж, хүн амын тоо, төрөлт, нас баралтын мэдээллийг Иргэний бүртгэлийн зэрэгцээ ҮСХ болон ЭМЯ давхар цуглуулж байгааг зогсоож, түүнийг улсын хэмжээнд зөвхөн иргэний бүртгэлийн мэдээлээс гаргадаг болох өөрчлөлтийг “Статистикийн тухай “ Монгол Улсын хуульд оруулах шаардлагатай байна.

Яам, агентлагуудаас гаргадаг захиргааны мэдээллийн хамралт, чанарт тавих хяналтыг сайжруулах чиглэлээр ҮСХ, яам, газруудтайгаа хамтран хийх ажил багагүй байна. Хэр ач холбогдолтой нь тодорхой бус, хэтэрхий олон тооны мэдээлэл цуглуулах явдал үргэлжилсээр, хамралт нь бүрэн бус, чанар, үнэн бодит байдал нь эргэлзээтэй тоо мэдээлэл цуглуулсаар байна. Жишээлбэл, 1000

амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2007 онд Говь-Алтай аймагт 32,5 байхад Төв аймагт дөнгөж 2,3 байв. Ийм их ялгаатай үзүүлэлт гарсан нь үнэхээр байдал газар дээрээ ийм байна уу, аль эсвэл хамрагдалт дутуугаас болов уу гэдгийг шалгах л хэрэгтэй байгаа юм. БСШУЯ –наас гаргадаг хамран сургалтын цэвэр жингийн үзүүлэлт онолын хувьд 100 – аас давах ёсгүй үзүүлэлт билээ. Гэтэл 1995 оны байдлаар энэ үзүүлэлт Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт 100- аас давж гарсан байсан. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл тухайн аймгийн сургуулийн насны хүүхдээс давсан тооны хүүхэд сургуульд сурч байсан болж харагдаж байгаа юм. Энэ мэтчилэн захиргааны мэдээллийн үнэн бодит байдал, чанарт шүүмжлэлтэй хандах тоо баримт цөөнгүй байна.

3. НҮБ-ын МХЗ-ыг дүгнэхэд манайхаас гаргаж чаддаггүй үзүүлэлтүүд, тэдгээрийг тоцох боломж

НҮБ-аас зөвлөмж болгосон МХЗ-уудыг дүгнэх 60 үзүүлэлтээс 8 үзүүлэлт нь манай орны хувьд хамааралгүй, харин 10 гаруй үзүүлэлтийг тоцох чадахгүй байгааг дээр дуудсан.

Манай орны хувьд дараахь 8 үзүүлэлтийг хамааралгүй гэж үзсэн

Үзүүлэлтүүд, хаалтанд тэдгээрийн код	Шалтгаан, тайлбар
1. Хумхаа өвчнөөр өвчлөгчид, тархалт, нас баралт (6.6)	Халуун орны энэ өвчин манай оронд бүртгэгдээгүй. Өмнө нь гарч байгаагүй өвчин.
2, Шумуулаас хамгаалсан тусгай оронд унтдаг 5 хүртэлх насны хүүхдийн болон хумхаагийн эсрэг эм хэрэглэсэн 5 хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь (6.7)	Дээрхт тайлбар энд мөн адил хамаарна.
Биологын аюулгүй хязгаарт байгаа загасны нөөц (7.3)	Энэ үзүүлэлт далай тэнгистай улс оронд хамаардаг.
4. ЭЗХАХ байгууллагын гишүүн орнуудын үндэсний орлогод эзлэх нэн буурай хөгжилтэй орнуудад олгосон хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь (8.1)	Манай орон нэн буурай хөгжилтэй орны ангилалд хамаарахгүй.
5. Арлын жижиг орнуудын авсан хөгжлийн албан ёсны тусламжийн үндэсний нийт орлогод нь эзлэх хувь (8.5)	Манай орон энэ ангилалын оронд хамаарахгүй
6. Хөгжингүй орнуудаас хөгжиж байгаа болон нэн буурай хөгжилтэй орнуудаас гаалийн татаваргүй оруулсан импортын эзлэх хувь (8.6)	Хөгжингүй орнуудад хамаарах үзүүлэлт
7. ЭЗХАХ байгууллагын гишүүн орнуудын үзүүлсэн хөдөө аж ахуйг дэмжсэн тусламжийн нийт үндэсний орлогод нь эзлэх хувь (8.8)	ЭЗХАХ байгууллагын гишүүн орнуудад хамаарах үзүүлэлт
8. Өрөнд баригдсан ядуу орны өрийг чөлөөлсөн хэмжээ (8.11)	Монгол Улс энэ ангилалд орохгүй. Дэлхийн банк, ОУВС-асс гаргадаг үзүүлэлт

МХЗ-ын хэрэгжилтийн талаарх 2004 онд гаргасан үндэсний анхны илтгэл болон 2007 онд хэвлэгдсэн 2 дахь илтгэл, ҮСХ-ны МХЗ-ыг дүгнэх

үзүүлэлтийн баазад хадгалагдаж байгаа үзүүлэлтүүдээс үзэхэд МХЗ- ыг олон улсын түвшинд дүгнэдэг, манай орны хувьд гаргаж чаддаггүй үзүүлэлтээс шинээр тооцсон үзүүлэлт сүүлийн жилүүдэд үндсэндээ байхгүй байна. Тэгэхлээр гаргаж чаддаггүй үзүүлэлтүүдээ тооцдог болох чиглэлээр ҮСХ болон холбогдох яам, газрууд хангалттай хүчин чармайлт тавиагүй байна.

Сүүлийн 10 – аад жилд манай оронд гаргаж, тооцож чадахгүй байгаа олон улсын түвшинд МХЗ-ыг дүгнэх зарим үзүүлэлтүүдийг доор харуулав.

Олон улсын түвшинд МХЗ- ыг дүгнэх үзүүлэлтүүд , хариуцах байгууллага	Гаргаж, тооцож чадахгүй байгаа шалтгаан
Зорилго 1.	
1.Өдөрт нэг ам. доллороос бага орлоготой, ажил эрхэлж байгаа хүний эзлэх хувь, (худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон) , ҮСХ	Худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон тооцоо байхгүй.
2. Хоногийн хүнсний илчлэг нь зөвшөөрөх доод түвшнээс доогуур байгаа хүн амын эзлэх хувь, ҮСХ	Манай оронд нэг хүний хоногийн илчлэгийн дундаж хэмжээг л тооцдог. Энэ үзүүлэлтийг тооцох боломжтой.
Зорилго 6.	
1.Сургуульд хамрагдсан 10-14 насны өнчин болон өнчин бус хүүхдийн харьцаа ,БСШУЯ	Өнчин хүүхдүүдийн сургалт хамрагдалтын тоо мэдээлэл гардаггүй.
2.ДОХ- ын халдвар тээгч, нэн шаардлагатай эмээр хангагдсан хүний эзлэх хувь, ЭМЯ	ЭМЯ ийм мэдээлэл хараахан цуглуулахгүй байгаа.
Зорилго 7.	
1.Нэг хүн амд болон ДНБ –ний нэг ам. долларт (PPP) ногдох угаарын хийн (CO2) ялгаруулалт, БОЯ, ҮСХ	Худалдан авах чадварын итгэлцүүрээр тооцсон ДНБ тооцоо байхгүй. Угаарын хийн ялгаруулалтын судалгаа муу.
2.Ашиглагдаж байгаа усний нийт нөөц, БОЯ, ҮСХ	Тоо мэдээлэл дутуу бүрэн бус.
3.Устаж үрэгдэхэд хүрсэн биологийн төрөл зүйлийн эзлэх хувь, БОЯ	Бүрэн мэдээлэл байхгүй.
Гэр оронгүй, хүнд нөхцөлд байгаа хүмүүсийн эзлэх хувь, ҮСХ	Бүрэн мэдээлэл байхгүй.
Зорилго 8.	
1. ЭЗХАХ байгууллагын гишүүн орнууд болон донор орнуудаас хоёр талын харилцааны шугамаар үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь,СЯ	ЭЗХАХ байгууллагын хөгжлийн тусламжийн хорооноос гаргадаг үзүүлэлт. Үндэсний хэмжээнд гаргах боломж муу.
2.Хөгжиж байгаа орнуудын ХАА- н болон нэхмэл бүтээгдэхүүн, хувцасны экспортод хөгжингүй орнуудаас олгосон тарифын хөнгөлөлт	Дэлхийн банк, Олон улсын худалдааны байгууллага, НҮБ хамтран гаргадаг үзүүлэлт
3.Наад захын шаардлагатай эмээр байнга хангагдсан хүн амын эзлэх хувь , ЭМЯ	ЭМЯ – мэдээлэлгүй байгаа

Хүснэгтээс харахад МХЗ-ын зарим гол зорило, зорилтуудыг дүгнэх үзүүлэлтгүй тул бүрэн дүгнэж чадахгүй байгаа нь тодорхой байна. Энэ шалтгаанаар МХЗ- ыг хэрэгжилтийн үндэсний илтгэлүүдэд эдгээр зорилтуудын хэрэгжилтийн талаар дүгнэлт ороогүй билээ.

Манай орны хувьд өдөрт нэг ам. доллороос бага орлоготой, ажил эрхэлж байгаа хүний эзлэх хувь, хоногийн хүнсний илчлэг нь зөвшөөрөх доод

түвшнээс доогуур байгаа хүн амын эзлэх хувь, ДОХ-ын халдвар тээгч, нэн шаардлагатай эмээр хангагдсан хүний эзлэх хувь, наад захын шаардлагатай эмээр байнга хангагдсан хүн амын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдийн хувьд тоо мэдээлэл олдох, эдгээр үзүүлэлтүүдийг тооцох боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Монгол Улсын Их Хурлын 2005 оны 25 –р тогтоол, 2008 оны 13 –р тогтоолуудаар батлагдсан Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд нь өөрийн орны өвөрмөц хэрэгцээ шаардлагыг тусгасны зэрэгцээ НҮБ-ын Мянганы Тунхаглалд дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч нэгдэн орсон зорилтуудаас зөрүүтэй тогтоогдсон байна.

Дээрх тогтоолуудаар батлагдсан МХЗ-уудыг дүгнэх зарим үзүүлэлтүүд нь НҮБ-аас зөвлөмж болгосон стандарт ойлголт, арга зүйгээс зөрүүтэй байна. Үүнээсээ болоод манай гаргаж байгаа үзүүлэлтүүдийг олон улсын хэмжээнд зэрэгцүүлэх боломжгүй байна.

Яам, агентлагуудаас гаргадаг захиргааны мэдээллийн хамралт, чанарт анхаарах зүйл их байна. Нэг тоог 3 байгууллага давхардуулан өөр өөрөөр гаргасар л байна.

МХЗ-ыг дүгнэх үзүүлэлтүүдэд сүүлийн жилүүдэд өөрчлөлт ороогүй, гаргаж чаддаг үзүүлэлтийн тоо үндсэндээ нэмэгдсэнгүй, гаргаж чаддаггүй үзүүлэлтээ гаргадаг болох талаар ахиц гарсангүй.

МХЗ-ыг дүгнэх үзүүлэлтээ олшруулах, мэдээллийн хамралт, чанарыг сайжруулах талаар ҮСХ болон яам, агентлагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

4. Санал, зөвлөмж

1. Манай орны Мянганы хөгжлийн зарим зорилтуудыг НҮБ-ын Мянганы Тунхаглалд тодорхойлсон хэмжээнд нийцүүлэн өөрчлөхийн тулд УИХ –ын 2005 оны 25 дугаар, 2008 оны 13 дугаар тогтоолуудад зохих өөрчлөлтүүд оруулах,

2. Манай орны Мянганы хөгжлийн зарим зорилтуудыг НҮБ-аас зөвлөмж болгосон олон улсын стандарт үзүүлэлтүүдээр нь дүгнэх шаардлагатай байна.

3. Мянганы хөгжлийн зорилтуудыг манай оронд дүгнэж байгаа зарим үзүүлэлтийг олон улсын стандарт ойлголт, тодорхойлолт, тооцох аргачлалд нь нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

4. Манай орны хувьд боломжтой тоо мэдээллийг цуглуулах, тооцох боломжтой үзүүлэлтүүдийг тооцох талаар ҮСХ болон холбогдох яам, агентлагууд хүчин чармайлт тавьж, ажиллах шаардлагатай байна.

5. МХЗ –ын 8 дугаар зорилгод хамаарах олон улсын холбогдох байгууллагуудаас тухайлбал, Дэлхийн банк, ОУВС –аас гаргадаг үзүүлэлтүүдийг тогтмол олж авч ашиглах талаар Сангийн яам тодорхой ажиллаж, үндэсний гурав дахь илтгэлд илүү өргөн хүрээтэй мэдээлэл ашиглан дүгнэлт гаргах шаардлагатай байна.

Ашигласан ном зүй.

1. ”Статистикийн тухай” Монгол Улсын Хууль, 1994 ,2006 он

2. УИХ –ын 2005 оны 4 –р сарын 21 –ний 25 -р тогтоол
3. УИХ –ын 2008 оны 1 –р сарын 31 –ний 13 -р тогтоол
4. “Мянганы Хөгжлийн Зорилтын хэрэгжилтийн өнөөгийн байдал” үндэсний илтгэл, 2004.
6. “Мянганы Хөгжлийн Зорилтын 2005-2006 оны хэрэгжилт” хоёрдахь илтгэл, Монгол улсын Засгийн газар , 2007
7. Master Plan for Education Development in Mongolia for 2006-2015, MECS and ADB, 2007
8. Manual for use of health primary recording and health administrative data reporting forms,
MoH, WHO, Ulaanbaatar, 2003
9. Indicators for Monitoring the Millennium Development Goals: *Definitions Rationale Concepts and Sources*. ST/ESA/STAT/SER.F/95 United Nations Publication; Sales No. E.03.XVII. 18; ISBN 92-1-161467-8; Copyright ©United Nations 2003
10. The Millennium Development Goals: Progress in Asia and Pacific 2007, UN, ADB, UNDP, 2007
11. Definitions of New MDG Indicators-Received by Benson from UNSD
12. Report of the Secretary-General of UN to the General Assembly’s 62nd session in August 2007.
13. Websites of international organizations
United Nations. Millennium Development Goals. <http://www.un.org/millenniumgoals>
UN Statistics Division. Millennium Indicators Database. <http://millenniumindicators.un.org>
United Nations Statistics Division. <http://unstats.un.org/unsd>
World Bank. Millennium Development Goals. <http://www.developmentgoals.org>
Living Standards Measurement Study (LSMS). <http://www.worldbank.org/lsms>
Multiple Indicator Cluster Surveys (MICS). Organisation for Economic Co-operation and Development. <http://www.oecd.org/dac>.
Demographic and Health Surveys. <http://www.measuredhs.com>
Food and Agriculture Organization of the United Nations. <http://www.fao.org>
International Labour Organization. <http://www.ilo.org/stat>
World Health Organization/United Nations Environment Programme Intergovernmental Panel on Climate Change. <http://www.ipcc.ch>
Organisation for Economic Co-operation and Development. Development Assistance Committee. <http://www.oecd.org/dac>
United Nations Development Group. <http://www.undg.org>

United Nations Development Program. Human Development Report. <http://www.undp.org/hdr2003>

United Nations Environment Programme. <http://www.unep.org>; UNEP.
United Nations Educational, Scientific and Cultural Organization. <http://www.unesco.org>
UNESCO Institute for Statistics. <http://www.uis.unesco.org>
United Nations Children’s Fund. <http://www.unicef.org> and <http://www.childinfo.org>

United Nations Framework Convention on Climate Change. <http://unfccc.int>
United Nations Population Fund. <http://www.unfpa.org>
United Nations Human Settlements Programme. <http://www.unhabitat.org>; and
<http://www.unhabitat.org/campaigns/tenure/introduction.asp>
World Conservation Monitoring Centre. Protected area data unit.
<http://www.wcmc.org.uk/data>
Joint United Nations Programme on HIV/AIDS. <http://www.unaids.org/hivaids> info
World Health Organization. Directly observed treatment short course (for tuberculosis). <http://www.who.int/gtb/dots>
World Bank. <http://www.worldbank.org/data>
World Bank. World Development Indicators. <http://www.worldbank.org/data>
World Resources Institute. <http://www.earthtrends.wri.org>
Biosphere reserves. <http://www.unesco.org/mab>
Heritage sites. <http://www.unesco.org/whc>
Wetlands. <http://www.ramsar.org/sitelist.pdf>